

1 - р ангид элсэх хүүхдийг сургуульд бүртгүүлэх тухай мэдээлэл.

Боловсролын тухай хуулийн дагуу бүртгэл 2021 оны 4-р сарын 1-ний өдрөөс эхлэн 2021 оны 4-р сарын 16 хүртэл явагдана.

1) Хүүхдийн эх эцэг сонгосон сургуулийн вэбсайтад орж, "Online zápis" "Онлайн элсэлт" гэсэнг дархад, бөглөх маягт нээгдэх ба шаардсан хувийн мэдээлэл, холбоо барих утас ба хаягаа бичиж бөглөнө. Дараа нь энэ маягтыг шууд сургуулийн системд автоматаар илгээнэ.

Хүүхдийн эцэг эх маягтыг бөглөсний дараа албан ёсны дагуу гарын үсгээ зурна. Хүүхдийн эцэг эх бөглөсөн pdf файлын хүснэгтээ хэвлэж гарын үсгээ зурж **хүүхдийнхээ төрсний гэрчилгээний хуулбар, (хэрэв та Европын Холбооны иргэн биш бол) байнгын эсвэл (урт хугацааны) оршин суух үнэмлэхийн хуулбартай** бүгдийг хамтад нь сургуульд дараах хэлбэрээр илгээнэ:

- a. Өөрийн биеэр Даваа, Лхагва гаригт (8: 00-11: 30), эсвэл сургуультай утсаар тохиролцсон аль нэгэн өдөр
- b. Шуудангаар (шуудангаар илгээсэн огноо оройтож үл болно)
- c. Мэдээллийн хайрцаг (Datova schránka)
- d. Хүүхдийн эцэг эхийн цахим гарын үсэгтэй имэйл - р

* Хүүхдийн эцэг эх маягтыг хувилах боломжгүй тохиолдолд сургуультай тохиролцож сургууль дээр хэвлүүлж болно.